

Оюуны Өмч Бизнес, Цуврал
Дугаар 2

ХАРАА БУЛААХУЙ

Жижиг Дунд Үйлдвэрлэлд зориулсан Бүтээгдэхүүний Загварын Танилцуулга

Санамж: Энэхүү гарын авлагад агуулагдаж буй мэдээллийг мэргэжлийн эрх зүйн зөвлөлгөө гэж ойлгож болохгүй юм. Энэ гарын авлагын зорилго нь үндсэн мэдээлэл өгөхөөр хязгаарлагдана.

МУОӨГ Зохиогчийн эрх (2004)

Энэхүү хэвлэлийн аль нэг хэсгийг ч, хуульд заасан зөвшөөрөлгүйгээр, зохиогчийн эрх эзэмшигчээс авсан бичгэн зөвшөөрөлгүйгээр ямарч хэлбэрээр эсвэл аль нэг зорилгоор, цахим байдлаар болон гар аргаар хуулбарлах болоод олшруулан тарааж болохгүй.

Удиртгал

Энэхүү гарын авлагад бүтээгдэхүүний загвар нь зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний амжилтыг тодорхойлогч гол хүчин зүйл болох талаар голчлон өгүүллээ.

Хараа булаахуй нэртэй энэ хэвлэл нь Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас Жижиг Дунд Үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулж гаргасан Бүтээгдэхүүний Загварын танилцуулга ба үндэсний нөхцөлд тохируулан хийсэн хувилбар юм. ДООБ-с олгосон зөвшөөрөл, заавар зөвлөмж болон туслалцаа дэмжлэг, Японы Патентийн Газрын санхүүгийн хамтын ажиллагаанд тулгуурлан энэ танилцуулга дахин сэргээгдэж, бэлтгэгдлээ. ДООБ-н энэ хэвлэлийн эх хувийг ДООБ-н ЖДҮ-н хэлтсийн (www.wipo.int/sme/) гэсэн вэбсайтаас PDF хэлбэрээр (Англи, Франц, Испани, Араб, Хятад мөн Орос хэлээр) олж авч үзэж болно. Энэхүү вэбсайтад жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн сонирхлыг татахуйц оюуны өмчийн асуудлаархи бусад ашигтай мэдээллүүд багтсан болно.

Оюуны өмчийн хууль тогтоомжид, бүтээгдэхүүний загвар нь аливаа бүтээгдэхүүний гоо сайхны болоод гадаад төрх харагдах байдалд хамааралтай болохыг заажээ. Энэ нь хэрэглэгчдийг болоод тэдний анхаарлыг нь татахуйц бүтээгдэхүүнийг хэрхэн хийх, мөн харахад анхаарал татахуйц байх нь хэрэглэгч нэг бүтээгдэхүүнийг нөгөөгөөс илүүд үзэж шийдвэр гаргахад нөлөөлөх үндсэн асуудлуудын нэг болдог байна. Бүтээгдэхүүний загвар нь компаниудад тэдгээрийн өрсөлдөгчөөсөө өөрсдийн

бүтээгдэхүүнээ ялгаатай байлгах болоод өөрсдийн бүтээгдэхүүнийхээ брэндийн нэр хүндийг сайжруулахад тусалдаг. Энэ нь бүтээгдэхүүний загварын зөв хамгаалалт хичнээн чухал болохыг баталж байна.

Энэ гарын авлага нь Монголын Жижиг Дунд Үйлдвэрлэл эрхлэгчдэд (ЖДҮ) зориулж бүтээгдэхүүний загварын хамгаалалтын талаар танилцуулах зорилготой бөгөөд асуулт, хариулт, жишээ болон батлагдсан бүтээгдэхүүний загварын зургуудаас бүрдэнэ.

Н.ЧИНБАТ,

Ерөнхий Захирал,
Монгол Улсын
Оюуны Өмчийн Газар

Агуулга

Хуудас

- 1 Бүтээгдэхүүний загвар
 - 2 Бүтээгдэхүүний загвараа хамгаалах нь
 - 3 Бүтээгдэхүүний загварыг гадаадад хамгаалах нь
 - 4 Бүтээгдэхүүний загвараа алдахаас сэргийлэх нь
 - 5 Бүтээгдэхүүний загварыг хамгаалах
- бусад эрх зүйн баримт бичгүүд

1. Бүтээгдэхүүний загвар

Бүтээгдэхүүний загвар гэж юу вэ?

Монгол улсын Патентийн тухай хуульд, “Бүтээгдэхүүний загвар” гэж үйлдвэрлэлийн аргаар хийх боломжтой бүтээгдэхүүний хэлбэр, хийцэд хамаарах өвөрмөц, цоо шинэ шийдлийг ойлгоно хэмээн тодорхойлсон байдаг.

Өдөр тутмын ярианд, бүтээгдэхүүний загварыг ерөнхийд нь бүтээгдэхүүний гаднах хэлбэр болоод үүрэг зориулалттай нь холбож ойлгодог. Түшлэгтэй сандал “сайхан загвар”– тай гэж хэлэх явцдаа энэ нь суухад биед тохиромжтой ба хараад таалж байгаагаа илэрхийлж байдаг. Бизнесийн үйл ажиллагаандаа зориулж, бүтээгдэхүүнийг загварчлах нь үндсэндээ тухайн бүтээгдэхүүний үүрэг зориулалт болоод гоо сайхны онцлог шинжүүдэд нь боловсруулалт хийх явдал бөгөөд ингэснээр бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадвар дээшилж, үйлдвэрлэлийн зардал мөн амархан зөөж тээвэрлэх, хадгалах, засварлах болоод тараан байрлуулах бололцоотой болгодог байна.

Оюуны өмчийн хууль тогтоомжийн агуулгаар бол, бүтээгдэхүүний загвар нь зөвхөн **эдлэл хэрэгслийн хээ чимэглэл болоод гоо сайхан харагдах байдалтай хамааралтай** байдаг. Өөрөөр хэлбэл, энэ нь зөвхөн түшлэгтэй сандлын гаднах харагдах байдалд хамаатай байна. Хэдийгээр эдлэл хэрэгслийн загвар нь техникийн эсвэл үүрэг зориулалтын онцлог шинж агуулсан байж болох боловч, оюуны өмчийн хууль тогтоомжид тодорхойлсноор, бүтээгдэхүүний загвар нь зөвхөн төгс хийгдсэн бүтээгдэхүүний гоо сайхны шинж байдалтай хамааралтай байх ба бүтээгдэхүүний ямар нэг техникийн эсвэл үүрэг зориулалтын онцлог тал нь салангид тусдаа байх юм.

Бүтээгдэхүүний загварт үйлдвэрлэлийн болон гар урлалын маш өргөн хүрээний бүтээгдэхүүнүүд хамаардаг, техникийн болон эмнэлгийн тоног төхөөрөмжүүдээс цаг хүртэл, үнэт чулуу, ба бусад өндөр үнэтэй чамин тансаг зүйлс; гэр ахуйн эдлэл хэрэгслээс тоглоом, тавилга ба цахилгаан хэрэгслээс эхлээд автомашин болон барилга байгууламжийн бүрдэл хэсэг хүртэл; нэхмэл бүтээгдэхүүнээс спортын тоног төхөөрөмж хүртэл багтана. Бүтээгдэхүүний загварт мөн сав, баглаа боодол болон бүтээгдэхүүний “гадна-төрх” чухал хамааралтай юм.

Ерөнхийдөө, бүтээгдэхүүний загварыг:


- гурван хэмжээст дүрслэлтэй, үүнд бүтээгдэхүүний **хэлбэр** багтана,
- хоёр хэмжээст дүрслэлтэй, үүнд **чимэглэл, хээ угалз, зураас** болон **өнгө** багтана,
- эдгээрээс нэг болон хэд хэдэн дүрслэл хосолсон гэж ангилдаг.

Гурван хэмжээст дүрслэлтэй бүтээгдэхүүний загварын жишээ:



Зөвшөөрсөн: “Ellis Advertising” ББН: Лонх

Хоёр хэмжээст дүрслэлтэй бүтээгдэхүүний загварын жишээ:



Зөвшөөрсөн: “Цагаан Гоёо” ХХК: Шошго



Зөвшөөрсөн: “Эн трэйд” ХХК: Шошго

Бүтээгдэхүүний Загвар зохион бүтээлт Бизнес

Үйлдвэрлэл эрхлэгчид нэлээд хэмжээний цаг хугацаа болон судалгаа шинжилгээг өөрсдийн бүтээгдэхүүний дизайн, харагдах байдлыг сайжруулахад байнга зарцуулдаг байна. Шинэ болоод жинхэнэ эх загварууд дараах зорилгоор байнга зохион бүтээгддэг байна:

1.Тусгайлсан зах зээлийн хэсэгт хандсан захиалгат бүтээгдэхүүнүүд: Зарим бүтээгдэхүүний загварт жижиг өөрчлөлт оруулахдаа (жишээ нь.цаг) өөр өөр насны бүлэг, өөр урлагын салбарт эсвэл нийгмийн аль нэг хэсэг бүлэг хүмүүст зориулан тэдэнд тохируулж хийж болно. Хэдийгээр цагны ажиллах зарчим, үүрэг зориулалт ижилхэн боловч, хүүхдүүд болоод насанд хүрэгчид загварт үндсэндээ маш өөр өөр сонголтоор ханддаг байна.

2. Шинэ “хэрэглэх хүрээний” зах зээл бий болгох: зах зээлийн өрсөлдөөнд, компаниуд өөрсдийн өрсөлдөгчөөсөө ялгарах шинж чанар бүхий шинэлэг бүтээгдэхүүний загвар бий болгон түүнийгээ танилцуулж чадсанаараа хэрэглэх хүрээний зах зээлийг бий болгодог. Энэ нь энгийн хэрэглээний эд зүйлс болох цоож, гутал, аяга ба хайчнаас нэлээд их үнэ бүхий эд зүйлс болох үнэт чулуу, компьютер болон автомашин байж болно.

3. Барааны тэмдгээ (Брэндээ) бэхжүүлэх: Шинэлэг загвар нь компаний тэмдэг (үүд)-ийн ялгарах шинжийг сайжруулах, ялгагдах барааны тэмдэгтэй байнга холбоотой байдаг. Маш олон компаниуд бүтээгдэхүүнийхээ загварт онцгой анхаарал хандуулснаар өөрсдийн брэндийн нэр хүндээ амжилттай бий болгоод зогсохгүй дахин шинээр тодорхойлсон байдаг.

Бүтээгдэхүүний загварыг яагаад хамгаалдаг вэ?

Бүтээгдэхүүний загвар бол бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлдэг. Энэ нь бүтээгдэхүүн хэрэглэгчдийн **анхаарлыг татаж, түүнчлэн тэднийг өөртөө татахуйц** болгодог, мөн худалдааны ховорхон үзүүлэлтийг ч үзүүлдэг байна. Иймээс үнэ цэнэтэй загвараа хамгаалах нь аль ч загвар зохион бүтээгч эсвэл үйлдвэрлэл эрхлэгчийн бизнесийн хэтийн төлөвлөгөөний чухал бүрэлдэхүүн хэсэг болдог байна.

Оюуны өмчийн газарт бүртгүүлж бүтээгдэхүүний загвараа хамгаалуулснаар, эрх эзэмшигч таны **зөвшөөрөлгүйгээр өөр бусад этгээд хуулбарлах эсвэл дууриалгахаас сэргийлэх онцгой эрхийг** олж авна. Энэ нь бизнесийн өрсөлдөх чадвар болон бизнесийн мэдрэмжийг нэмэгдүүлдэг байна. Цаашлаад дараах нэг буюу хэд хэдэн аргуудаар нэмэлт орлого байнга олж авдаг:



Зөвшөөрсөн: *Д.Болдбаатар: Арьсан түрийвч*

- Бүтээгдэхүүний загвараа бүртгүүлснээр та өрсөлдөгч этгээд таны загварыг хуулах болон дууриалгахаас сэргийлж чадна, үүний үндсэн дээр таны өрсөлдөөний байр суурь бэхжинэ.
- Үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүний загвараа бүртгүүлэх явдал нь тухайн бүтээгдэхүүнийг зохион бүтээхэд болоод зах зээлд гаргахад оруулсан **хөрөнгө оруулалтаасаа боломжийн ашиг олж авах** бололцоотой болгоод зогсохгүй цаашид ашгийг нэмэгдүүлэхэд ихээхэн ач тустай.
- Бүтээгдэхүүний загвар нь тухайн бүтээгдэхүүнийг болоод компаний худалдааны ашгийг нэмэгдүүлэх **бизнесийн хөрөнгө** болдог. Дизайныг чухалчлах явдал нь компаний ашиг орлогыг улам ихэсгэдэг байна.
- Эрх нь хамгаалагдсан бүтээгдэхүүний загварыг төлбөртэйгээр бусдад ашиглуулахаар **лицензийн гэрээ** хийж(эсвэл худалдаж) болно. Лицензийн гэрээ хийснээр, та өөрөө хэрэглэх ашиглах боломжгүй байсан ч зах зээлд нэвтрэн орж чадах юм.
- Бүтээгдэхүүний загварын бүртгэл нь **шударга өрсөлдөөн** болоод тааламжтай худалдааны хэрэглээ, практикт уриалан дууддаг, энэ нь эргээд гоо сайхны хувьд анхаарал татаж чадахуйц олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх санааг төрүүлдэг байна.

Европын Холбооны Орнуудад бүтээгдэхүүний загварыг хамгаалж буй шалтгаан



Эх сурвалж: ОНIM, Дотоодын Зах Зээлийг Зохицуулах Байгууллага, Европын Холбооны Орнуудын түвшинд Бүтээгдэхүүний Загварын бүртгэлийн талаарх хэтийн төлөвийн судалгаа (2002)

Дизайнд түүний харагдах байдал нөлөөлөх нь

Хэдийгээр ширээний үүрэг зориулалт нь нэг бүтээгдэхүүнээс нөгөө бүтээгдэхүүнд тодорхойлогдох үндсэн ялгаа байдаггүй ч, түүний харагдах байдал нь зах зээл дээрхи амжилтыг тодорхойлогч гол зүйлийн нэг болж байдаг байна. Иймээс олон оронд гэр ахуйн зориулалттай бүтээгдэхүүн болох ширээний загвар нэлээд олон тоотой бүртгэгдсэн байдаг.



Зөвшөөрсөн: Ө.Жүгдэр: Ширээ

2. Бүтээгдэхүүний загвараа хамгаалах нь

Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтыг хэрхэн хийлгэх вэ?

Монгол улсад, **бүтээгдэхүүний загварыг Патентийн тухай хуулийн дагуу** хамгаалж бүртгэх ёстой байдаг.

Бүтээгдэхүүний загвараа бүртгүүлэхийн тулд та эрхийн хамгаалалт хийлгэхийг хүссэн өргөдлийг **Монгол Улсын Оюуны Өмчийн Газарт** гаргах ёстой.

(Хавсралт I - т Оюуны Өмчийн Байгууллагуудын веб сайтын /хуудасны/ жагсаалт бий)
Гадаадад бүртгүүлэх талаар зөвлөмжийн 3 – р хэсгээс харна уу.

Энэ зөвлөмжид үндсэндээ бүртгэгдсэн бүтээгдэхүүний загварын талаар голчлон тайлбарлана, энэ нь бүтээгдэхүүний загварын бүртгэл маш их ач холбогдолтой болохыг гэрчилж байгаа юм. Бүтээгдэхүүний загварыг хамгаалах хэд хэдэн арга замууд байдаг байна:

- Бүтээгдэхүүний загварын төрлөөс хамааран, бүтээгдэхүүний загварыг хамгаалах аргын нэг нь **зохиогчийн эрхийн хууль** байдаг байна. Зохиогчийн эрх нь үндсэндээ утга зохиол уран сайхны бүтээлийг хамгаалах онцгой эрхэд хамаардаг. Зарим бүтээгдэхүүний загварыг урлагийн бүтээл эсвэл хавсрага урлагийн бүтээл маягаар авч үздэг бөгөөд зохиогчийн эрхийн хамгаалалтаар **Жижиг Дунд Үйлдвэрлэл эрхлэгчдийн сэтгэлийг татах сонголтыг хийлгэх буюу түүгээр орлуулж болдог.**
- Хэрэв бүтээгдэхүүний загварын үүргийг зах зээл дээр барааны тэмдгээр авч үзсэн бол, энэ нь **гурван хэмжээст/эзэлхүүнт тэмдгээр** бүртгэгдэж болно. Энэ нь аль нэг ялгарах онцгой шинжтэй хийгдсэн бүтээгдэхүүний хэлбэр эсвэл түүний сав баглаа боодолд хамаарч байж болно.
- Өрсөлдөгч этгээд дууриалгахаас сэргийлж компанийн бүтээгдэхүүний загварыг **шударга бус өрсөлдөөнийг** хориглох хуулиар хамгаалж болдог байна.

Та өөрийн бүтээгдэхүүний загвараа зохиогчийн эрхээр, барааны тэмдгээр мөн түүнчлэн **шударга бус өрсөлдөөнийг** хориглох хуулиар хамгаалах талаар илүү нарийвчилж Зөвлөмжийн 5-р Хэсгээс олж үзээрэй.

Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтаар ямар эрхүүд олгогдох вэ?

Бүтээгдэхүүний загварыг бүртгүүлж хамгаалуулснаар, бүтээгдэхүүний загварын эзэмшигч гуравдагч этгээд тэрхүү бүтээлийг **зөвшөөрөлгүйгээр олшруулж хувилах эсвэл хуулбарлахаас сэргийлэх эрхийг** олж авдаг байна. Үүнд нийлмэл дизайны эсвэл хавсрага бүтээгдэхүүний загварын аль ч эдлэл хэрэгслийг **хийх, санал болгох, гадаадаас оруулж ирэх, гадаадад гаргах буюу худалдаалахаас** бусад хасагдсан эрхүүд багтана. Оюуны өмчийн хууль тогтоомж болон практик хэрэглээ нь бүртгэгдсэн бүтээгдэхүүний загварын хамгаалалтын бодит цар хүрээг тодорхойлдог.

Онцгой эрх

Танай компани шинэлэг дизайн бүхий гүц зохион бүтээж түүнийгээ Монгол Улсын Оюуны Өмчийн Газарт бүртгүүлж, гүцний гаднах дизайн бүхий бүтээгдэхүүний загвараа өмчлөх онцгой эрхийг олж авсан гэж бодъё. Энэ нь юу гэсэн утгатай вэ гэвэл, та ижил загвар бүхий гүцийг таны өрсөлдөгч тал хийж, худалдаалж мөн түүнчлэн гадаадаас оруулж ирж буйг илрүүлсэн бол, та өрсөлдөгч талд таны бүтээгдэхүүний загварыг ашиглахаас сэргийлж, боломжтой бол, бүтээгдэхүүний загварыг зөвшөөрөлгүйгээр хэрэглэснээс таны бизнест учрах хохирлын нөхөн төлбөрийг олж авч болно.

Тэгээд, өрсөлдөгч тал өрсөлдөх бүтээгдэхүүнээ хийсээр буйг та зогсоож чадаагүй байвал та тэдэнд таны бүтээлтэй яг адилхан харагдах бүтээгдэхүүн хийхийг болон таны бүтээлийг ямар нэг үнэ төлбөр төлөхгүйгээр авч ашиглахаа зогсоохыг урьдчилан

сануулж болно. Та өөрийн эрхээ хэрхэн хэрэгжүүлэх талаар илүү нарийвчлан мэдэхийг хүсвэл оюуны өмчийн хуульчаас зөвлөлгөө авахыг санал болгож байна.



Зөвшөөрсөн: Б.Амартуяа: *Бэлэг дурсгалын хүүхэлдэй*

Бүтээгдэхүүний загвараар юу бүртгэгдэх вэ?

Бүртгэгдэх боломжтой бүтээгдэхүүний загвар нь Монгол улсын Патентийн тухай хуульд заасны дагуу дараах үндсэн шалгуурыг хангасан байх ёстой:

- Бүтээгдэхүүний загвар нь **“шинэ”** байх ёстой. Бүтээгдэхүүний загвар шинэ байна гэдгийг, загварыг бүртгүүлэхээр мэдүүлсэн мэдүүлгийн анхдагч огнооноос өмнө адил төстэй загвар олон нийтэд тархаж мэдэгдээгүй байна хэмээн ойлгоно.
- Бүтээгдэхүүний загвар нь **“жинхэнэ буюу эх”** загвар байх ёстой. Бүтээгдэхүүний загвар нь жинхэнэ байна гэдэгт тухайн загварыг загвар зохион бүтээгч нь бие даан зохион бүтээсэн болон тухайн бүтээгдэхүүний загварын хувилсан ба хуулбарлан дууриалгасан загвар биш байна.
- Бүтээгдэхүүний загвар нь **“өвөрмөц шинж чанар”** - тай байна. Энэхүү шаардлага нь мэдээлж буй хэрэглэгчийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний загварын гадаад хэлбэр дүрс нь олон нийтэд түгэж мэдэгдсэн аль нэг өмнөх хэрэглэгчийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний гадаад хэлбэр дүрсээс ялгаатай байх тэр үед хангагдана.

Уламжлалын дагуу, хамгаалагдах боломжтой бүтээгдэхүүний загвар нь үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнтэй хамааралтай байна, үүнд гутлын хэлбэр дүрс, ээмэгний дизайн эсвэл гүцны хээ чимэглэл багтана.

Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтаар юу хамгаалагдахгүй вэ?

Дараахь зүйлүүдийг бүтээгдэхүүний загвараар бүртгэхийг үндсэндээ хориглодог. Үүнд:

- Шинэлэг, жинхэнэ байдал ба/ эсвэл өвөрмөц шинжийн шаардлагуудыг хангаагүй бүтээгдэхүүний загвар (дээр тайлбарласанчлан).
- Тухайн бүтээгдэхүүнийхээ **техникийн үүрэг зориулалттай** нягт холбоотой дизайн ; тэрхүү техникийн шинжтэй эсвэл үүрэг зориулалтын шинжтэй бүтээгдэхүүний загварын онцлог талууд, тус бүрийн нөхцөл байдлуудаас хамааран, бусад аж үйлдвэрийн өмчийн эрхүүдээр хамгаалагдаж болно.(патент, ашигтай загвар мөн худалдааны нууц г.м.)

- Бүтээгдэхүүний загвар нь **хамгаалагдсан бэлэг тэмдэг эсвэл эмблемүүдийг** агуулсан байвал (үүнд үндэсний туг далбаа г.м).
- Бүтээгдэхүүний загвар **олон нийтийн дэг журам мөн ёс суртахуунд харшлаж** байвал.

Монгол Улсын Патентийн тухай хууль тогтоомжид бүтээгдэхүүний загвараар юу юу бүртгэгдэхгүй вэ гэсэн хязгаарлалтуудыг тогтоосон байдаг. Энэ талаар аж үйлдвэрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч эсвэл Монгол Улсын Оюуны Өмчийн Газраас зөвлөгөө авахыг санал болгож байна.

Бүтээгдэхүүний загварыг хэрхэн бүртгүүлэх вэ?

Та өөрийн оронд бүтээгдэхүүний загвараа бүртгүүлэхийн тулд дараах үе шатыг дагах хэрэгтэй:


- Монгол Улсын Оюуны Өмчийн Газраас гаргасан **мэдүүлгийн маягтын** дагуу өргөдөл мэдүүлэх ёстой(Та бүтээгдэхүүний загвараа бүртгүүлж болох аж үйлдвэрийн өмчийн газруудын вебсайтуудын жагсаалтыг Хавсралт I – с харна уу). Мэдүүлгийн маягтад, та юуны түрүүнд өөрийн нэр, харилцах тодорхой хаяг зэргийг асуулгын дагуу бөглөж мөн бүтээгдэхүүний загвар(уудын) зураг эсвэл фото зураг зэргийг хавсаргасан байхыг шаардана.
- Таны мэдүүлэгт бүтээгдэхүүний загвар(ууд)ын **тодорхойлолт буюу шинэлэгийн нотолгоо** бичигдсэн байхыг шаардана. Тодорхойлолт нь үндсэндээ мэдүүлж байгаа бүтээгдэхүүний загварт л хамаатай, харин түүний бүрдэл хэсэгт хамаарахгүй. Тодорхойлолт нь аль нэг өмнөх мэдэгдсэн ижил төстэй бүтээгдэхүүний загвараас ялгаатай болохыг нягт нарийн, хангалттай тогтоосон байх ёстой. Тодорхойлолтод бүтээгдэхүүний загварын бүхий л гоо сайхны өвөрмөц шинж чанаруудыг тусгасан байх ба түүнчлэн чухал ач холбогдолтой гэж үзсэн шинж чанаруудыг тайлбарласан байна. Шинжээч нь загварыг сайн бодитой үнэлэх үүднээс эсвэл түүний нэхээс эсвэл материалыг мэдэрч таних үүднээс бүтээгдэхүүний загварын дээж загварыг авчруулахыг шаардаж болно.
- Мөн та **тогтоосон мэдүүлгийн хураамжийг төлөх** шаардлагатай. Та мэдүүлэг гаргах болон бүртгэлийн үйл явцад оруулахад туслалцаа үзүүлэх аж үйлдвэрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг ажиллуулахаар сонгон авч болно. Энэ тохиолдолд, **таныг төлөөлж буй итгэмжлэлийг гэрчилсэн баримт бичгийг** мөн мэдүүлнэ.

Монгол улсын Оюуны Өмчийн Газар нь тухайн бүтээгдэхүүний загварыг бүртгэхийн тулд шинэлэг эсвэл жинхэнэ загвар болох эсэхийг шалгадаг.

Бүтээгдэхүүний загвар бүртгэгдсэн тохиолдолд, тэрээр бүтээгдэхүүний загварын бүртгэлд орж, бүтээгдэхүүний загварын албан ёсны хэвлэлд хэвлэгдэн, танд **бүтээгдэхүүний загварын патент олгогдоно.**

Бүтээгдэхүүний загвараа гадаадад хэрхэн хамгаалуулах талаар 3-р хэсэгт нарийвчлан заасан болно.

Бүтээгдэхүүний загварын хамгаалалтын үе шат



Бүтээгдэхүүний загварыг бүртгүүлэхэд хэдий хэр хугацаа зарцуулах вэ?

Монгол Улсын Патентын тухай хуульд зааснаар бүтээгдэхүүний загварын бүртгэлийн үйл явц нь үндсэндээ 6-12 сар байдаг, мөн хэвлэлд нийтлэгдсэн нь бүтээгдэхүүний загварын шинжээч эсэргүүцэх үндэслэлийг бий болгож байгаа эсвэл бүтээгдэхүүний загварын шинжээч авч үзээд бүтээгдэхүүний загвараар бүртгэхээс татгалзах заалт байсан зэргээс шалтгаалж түүнээс урт байдаг.

Бүртгүүлэхээс өмнө бүтээгдэхүүний загварыг нууцалж хадгалах нь ямар ач холбогдолтой вэ?

Та бүтээгдэхүүний загвараа бүртгэлийн тогтолцооны дагуу хамгаалуулахыг хүсэж байгаа бол, загвараа нууцалж хадгалах нь үнэхээр их чухал болно. Үүний шалтгаан нь бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын гол шалгуур болох загвар нь “шинэ” байх ёстой гэсэн асуудал болно. Хэрэв та өөрийн зохион бүтээсэн загвараа бусдад үзүүлэх бол, бичгэн гэрээгээр нууцад байлгана, бүтээгдэхүүний загвар нууц байна гэдгийг баталгаажуулах нь тустай болно.

Бүтээгдэхүүний загвар нь олон нийтэд аль хэдийнэ танил болсон бол, жишээ нь, тухайн загвар танай компаний сурталчилгааны сэтгүүл болон ном товхимолд тавигдчихсан бол тэрээр “шинэ” гэж удаан тооцогдохгүй болно.

Жишээ: “Монгол Богц” ХХК

Монголын “Монгол Богц” компани нь монгол ардын уламжлалт хэрэглээний зүйлс, арьс ширэн дашмагыг орчин үеийн шинэ техник технологи ашиглан үйлдвэрлэх санааг анх сэдэж, 1999 оноос ажиллаж эхэлжээ.

Юуны түрүүнд, дашмагны загвар дизайныг чухалчилж, нэлээд судалгаа шинжилгээ явуулж олон тооны шинэ загваруудыг зохион бүтээсэн байна. Хөдөөгийн ард түмний өдөр тутмын хэрэглээний бүтээгдэхүүн болох дашмаг богцыг үйлдвэрлэх явцдаа, энэхүү уламжлалт бүтээгдэхүүнийгхотын суурин хэрэглэгчдэд хүргэх санааг сэдсний үр дүнд бэлэг дурсгалын байдлаар, багасгасан загвараар үйлдвэрлэж болох санааг олжээ.

“Монгол Богц” ХХКомпани нь эдгээр шинэ бүтээгдэхүүнүүдээ хамгаалах тал дээр бүтээгдэхүүний загварын үндэсний мэдүүлэг 2002 онд гаргаж, бүтээгдэхүүний загварын патент авсан байна.

Өнөөдөр “Монгол Богц” ХХКомпаний арьс ширэн цүнх дашмаг, бэлэг дурсгалын зориулалттай бүтээгдэхүүнүүд эрэлт хэрэгцээ ихтэй, ялангуяа тус компаний гол бүтээгдэхүүн болох дашмаг нь гадны жуулчдын анхаарлыг ихээхэн татаж борлуулалт сайтай болжээ.



Зөвшөөрсөн: “Монгол богц” ХХК: Арьсан бүрээстэй лонх

Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт хэр зэрэг удаан үргэлжлэх вэ?

Бүртгэгдсэн бүтээгдэхүүний загварын хамгаалалтын хугацаа орон оронд харилцан адилгүй байдаг ба Монголд Патентийн тухай хуульд зааснаар бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын хугацаа **10 жил** байна хэмээжээ,.

Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт хийлгэх хөлс ямар үнэтэй вэ?

Бодит үнэ хөлс орон оронд илэрхий ялгаатай байна. Гэвч, энэ нь хийгдэх үйл ажиллагаанаас хамаарч үнийн төрлүүд өөр өөр байдаг гэдгийг сануулах ач холбогдолтой юм:

1. Монгол Улсын Оюуны Өмчийн Газарт бүртгэлийн хураамж төлөгдсөн байна. Хураамж нь үндсэндээ ажил үйлчилгээний хөлс болоод улсын хураамж гэсэн хоёр төрлөөс бүрддэг. Ажил үйлчилгээний хөлсөд хайлт шүүлт хийлгэх, патентийн эрх шилжүүлэх төлбөр зэрэг багтах ба жишээ нь хайлт шүүлт хийлгэх хөлс 16000 төгрөг байдаг. Улсын хураамжыг патент эзэмшигч гурав гурван жилээр төлж болох бололцоотой ба энэ нь эхний гурван жилд 6960 төгрөг, дараагийн гурван жилд 9000 төгрөг, сүүлчийн гурван жилд 22000 төгрөг төлөгддөг

байна. Хураамжийн талаар илүү тодорхой нарийвчлан мэдэхийг хүсвэл аж үйлдвэрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид эсвэл Монгол Улсын Оюуны Өмчийн Газраас тодруулж болно.

2. Хэрэв та мэдүүлэг гаргахыг тулд шинжээчийн зөвлөлгөөг даган сонголт хийж бүртгэлийн үйл ажиллагаанд таныг төлөөлж ажиллах **аж үйлдвэрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээг хөлсөлсөн үнэ төлбөр** бас багтаж болно.

3. Хэрэв бүтээгдэхүүний загвараа гадаадад хамгаалуулсан бол бүтээгдэхүүний загварын **орчуулгын үнэ** багтаж болно.

Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт ба бизнесийн хэтийн төлөвлөлт

Компанийхаа бүтээгдэхүүний загварыг хэзээ, хаана, хэрхэн хамгаалуулах вэ гэдэг шийдвэр гаргах явдал нь загварын удирдлагын бусад салбарт ч ач холбогдолтой байдаг байна. Иймээс үйлдвэрийн өргөн хүрээтэй бизнес төлөвлөлтөд бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын асуудлыг нэгтгэх нь маш чухал юм. Жишээлбэл, хамгаалалтын хэлбэр, үнэ хөлс, хамгаалалтын үр дүн болон бүтээгдэхүүний загвар эзэмшигчийн асуудал зэргийг шийдснээр маш ашигтай байж болох юм:

- Дотооддоо бүтээгдэхүүний загварыг хөгжүүлэхийг оролдох эсвэл гадаадын төлөөлөгчид захиалах;
- Шинэ бүтээгдэхүүний загварыг зар сурталчилгаа, зах зээл дээр эсвэл үзэсгэлэнгээр олон нийтэд дэлгэн үзүүлэх анхны хэрэглээний цаг хугацааг товлох;
- Гадаад зах зээлийг төлөвлөх;
- Хэзээ, хэрхэн лицензийн гэрээ хийх эсвэл эдийн засгийн хувьд нөхөн төлөх болзолтойгоор бусад компанид худалдааны ашиг орлого олох зорилгоор бүтээгдэхүүний загвараа шилжүүлэх;

Та өөрийн бүтээгдэхүүний загвараа гоо сайхны өвөрмөц шинжтэй болоод үүрэг зориулалтын өөрчлөн сайжруулалттай байлгахын тулд юу хийх хэрэгтэй вэ?

Аливаа бүтээгдэхүүний **үүрэг зориулалтын өөрчлөн сайжруулалтыг** хамгаалуулахад, гол нь **патент** эсвэл **ашигтай загварын хамгаалалтаар** мөн үүрэг зориулалт нь тухайн бүтээгдэхүүнтэйгээ илэрхий уялдаатай биш бол загвараа **худалдааны нууцаар хадгалуулахаар** мэдүүлж болно гэж зөвлөх байна. Гэхдээ, шинэ бүтээгдэхүүн нь бүтээлч гоо сайхны шинжтэй зориулалтын өөрчлөн сайжруулалт хийгдсэн байхыг харна. Таныг автомашины шинэ жолооны хүрд зохион бүтээсэн гэж тооцъё.

Жолооны хүрд нь цахилгаан эсвэл механик бүрдэл бүхий хэд хэдэн дэвшилттэй учир патентаар хамгаалагдах боломжтой, таны жолооны хүрд нь жинхэнэ эх загвар тул бүтээгдэхүүний загвараар бүртгэгдэх боломжтой байж болно. Та хоёулангаар нь мэдүүлж болох уу?. Хариулт нь “тийм” байна.



Зөвшөөрсөн: Зохион бүтээгч Б.Амарбат: Тэрэг GS-A

Олон зохион бүтээгчид өөрсдийн өөр өөр шийдэл бүхий бүтээгдэхүүнүүдээ оюуны өмчийн өөр өөр эрхүүдээр хамгаалуулдаг. Энэ нь ихээхэн ач холбогдолтой хэдий ч патент/ашигтай загвар болон бүтээгдэхүүний загварын хоорондын үндсэн ялгааг оюун ухаандаа мэдэрч байх хэрэгтэй. **Бүтээгдэхүүнд үүрэг зориулалтын өөрчлөн сайжруулалт агуулагдаж байгаа бол шинэ бүтээлийн патент/ашигтай загвараар мөн бүтээгдэхүүний гаднах харагдах байдал бүтээгдэхүүний загвараар хамгаалагдана.**

Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт хийлгэхээр хэн мэдүүлэг гаргаж болох вэ?

Ерөнхийдөө, бүтээгдэхүүний загварыг зохион бүтээсэн хэн боловч эсвэл, гэрээний дагуу ажиллаж буй бол, түүний ажил олгогч нь дизайныг бүртгүүлэхээр мэдүүлэг гаргаж болно. Мэдүүлэг гаргагч нь хувь хүн (зохион бүтээгч) эсвэл хуулийн этгээд (компани гэх мэт) байж болно. Нөгөөтэйгүүр мэдүүлгийг шууд эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан гаргаж болно. Хэрэв та гадаадын мэдүүлэг гаргагч бол та тухайн орны аж үйлдвэрийн өмчийн байгууллагаар зохих ёсоор зөвшөөрөгдсөн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн хүсэлт гаргаж болно.

“Мон - Тү - Өв” компани

“Мон Тү Өв” компани нь 1990 онд анх байгуулагдан өнөөдрийг хүртэл амжилттай хөгжиж ирлээ. Тус компани нь Монголын угсардаг тоглоом, сэтгэхүй хөгжүүлэх тоглоом болон бусад бэлэг дурсгалын зүйлс, гар урлалын бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж мөн гадаадад гаргадаг компани юм. “Мон Тү Өв” компани нь өөрийн оюун ухааны музейг ажиллуулдаг байна, тэрхүү музейд олон мянган сонирхолтой, гайхаш төрүүлэм тоглоомуудыг дэлгэн үзүүлжээ.

Музейн сан хөмрөгт олон тооны дэлхийд алдартай, ховор мөн дээр үеийн үзмэрүүд багтдаг. Жишээ нь; Алт, мөнгө, эрдэнийн чулуу болон мод ашиглаж түгжигддэг аргаар хийгдсэн 200 гаруй төрлийн Монголын угсардаг шатрын иж бүрдэл байна.

Түүнчлэн “Эйфлийн цамхаг”, “Эрх чөлөөний хөшөө”, “Египетийн цамхаг” гэх мэт алдартай бүтээлүүдийг угсардагаар хийсэн үзмэрүүдийг мөн 673 төрлийн түгжигддэг модон загварууд болон 5000 угсардаг бүтээлүүдийг дэлгэн үзүүлжээ. Хамгийн том болоод хамгийн жижиг шатрын иж бүрдэл ихээхэн анхаарал татдаг байна, хамгийн жижиг шатар нь 5-10мм, харин хамгийн том шатрын хүү нь 35-55см өндөртэй, шатрын хөлөг нь 7.6м байдаг байна.

Эдгээр тоглоомууд нь бүхий л насныханд тоглонгоо сурч боловсрон маш их ач холбогдолтой хэрэглэгдэхүүн болдог.

Үүрэг зориулалтын шинж чанар бүхий угсардаг, сэтгэхүй хөгжүүлэх тоглоомууд болон бүтээгдэхүүнүүд бүтээгдэхүүний загвараар хамгаалагдсан.



Зөвшөөрсөн: “Мо-Тү-Өв” ХХК: Иж бүрдэл шатар

Бүтээгдэхүүний загвараар олгогдсон эрхийг хэн эзэмших вэ?

Бүтээгдэхүүний загварын зохион бүтээгч, дизайнер г.м. нь ихэвчлэн тодорхой нөхцөлгүйгээр тухайн бүтээгдэхүүний загварын анхны эзэмшигч болдог. Жишээ нь, хэрэв **ажилтан** хөдөлмөрийн гэрээний хугацаанд бүтээгдэхүүний загварыг бий болгосон бол, энэ нь тухайн үйлдвэр дээр түүний ажлын цагаар мөн тухайн үйлдвэрт ажил үүргийн хуваарийн дагуу хийгдсэн бол, тухайн бүтээгдэхүүний загвар (болон хамаарах эрх) нь ажил олгогчид хамааралтай байна эсвэл бичгэн гэрээ хэлэлцээрээр шилжүүлэх хүсэлтийг гаргаж болно.

Хэрэв бүтээгдэхүүний загварыг **гэрээний үндсэн дээр ажилладаг гадны зохион бүтээгч** бий болгосон бол, тэрхүү бүтээгдэхүүний загварын эрх нь үндсэндээ тухайн загварыг захиалсан компанид л хамаарах болно. Ийм тохиодолд, загварыг захиалсан хувь хүн, эзэмшигчийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэдэг. Эрх эзэмшигчийн асуудлаархи заалтыг зохион бүтээгчтэй жинхэнэ гэрээ хэлэлцээрт тодруулж өгснөөр сүүлд нь буруу ойлголцолд хүрэхээс сэргийлдэг байна. Мөн тухайн бүтээгдэхүүний зохион бүтээгч нь жинхэнэ эх бүтээгдэхүүний загварыг зурснаар зохиогчийн эрхийн хамгаалалт түүнд автоматаар хийгдэх ба энэ тухай заалт нь гэрээгээр шийдвэрлэгддэг гэдгийг оюун санаандаа сайн тогтоох хэрэгтэй юм.

Маш олон загваруудыг нэг мэдүүлгээр бүртгүүлэхээр мэдүүлэг гаргаж болох уу?

Монголд олон загварыг (50 хүртэлх загварыг) бүртгүүлэхээр нэг мэдүүлгээр мэдүүлж болдог, харин тэдгээр нь бүгдээрээ нэгэн төрлийн бүтээгдэхүүнүүдэд эсвэл нэг “ангилал”-д хамааралтай байна (доор дурьдсан “ангилал” тайлбарыг харна уу). Энэ нь, хэрэв та сандлын, ширээний ба хувцасны шүүгээний иж бүрдэл зохион бүтээгээд, түүнийгээ бүгдийг нь хамгаалуулах сонирхолтой байгаа бол, гэхдээ тэдгээр бүтээгдэхүүнүүд бүгдээрээ нэг ижил ангилалд хамаарч байвал, олон оронд тэдгээр бүх загваруудаа хамтад нь нэг мэдүүлгээр мэдүүлэхийг, мөн зөвхөн нэг мэдүүлгийн хураамж төлөхийг зөвшөөрнө гэсэн утгатай. Гэхдээ мөн та чийдэнгийн хавсрага дагалдах хэрэгслийг хамгаалуулахыг хүсч байгаа бол тэдгээрт тус бүрт нь мэдүүлэг гаргахаар хүсэлт гаргаж ч болно. Чийдэнгүүд нь, үндсэндээ, бүтээгдэхүүний нэгэн

ижил ангилалд хамаараагүй байна. Ерөнхийдөө, хураамжыг нэмэлт загвар тус бүрт төлөх шаардлагатай боловч, энэ нь загвар тус бүрт нь мэдүүлэг гаргах үнээс харьцангуй доогуур байдаг.

Үйлдвэрлэлийн хувиралтад, жишээ нь нэг нь цахилгаан товчтой, нөгөө нь дугуй товчтойгоороо ялгаатай хоёр хүрэмний загвар мөн хамаарагдана.

Өөр нэг жишээ гэвэл, ээмэгний загвар, нэг нь цоологчтой ээмэг, нөгөө нь цоолсон чихэнд зориулсан ээмэг гэсэн ялгаатай.

- **Хувилбаруудад** багтааж болно, жишээ нь хоёр ээмэг, тэдгээрийн ялгаа нь нэг нь цоологчтой ээмэг харин нөгөө нь цоолсон чихэнд зориулсан ээмэг байна. Хувилбар гэдгийг, бүтээгдэхүүний загвар нэг нь нөгөөгөөсөө ялгарах онцгой ялгаа байхгүй нэгэн ижил төрлийн хэрэгсэл, бүтээгдэхүүн байна гэж ойлгоно.
- “Иж бүрдэл” гэдгийг, өөрөөр хэлбэл, нэгэн ижил ерөнхий шинж чанартай, тэдгээр нь хамтдаа зарагддаг, эсвэл хамтдаа хэрэглэгддэг, болон загварын зарим нийтлэг онцлог шийдэлтэй хэд хэдэн хэрэгсэл байна гэж тодорхойлно. Жишээнд, хутганы төрөл зүйл (сэрээ, халбага, хутга), шилэн эдлэл (цагаан дарсны, улаан дарсны, жимсний шүүсний), болон гэр ахуйн хэрэгсэл (үс хатаагч сэнс болон түүний хошуу ба сойз) багтана.

Нэг мэдүүлэгт хичнээн олон хувилбар багтах боломжтойг та харлаа; ийнхүү аж үйлдвэрийн өмчийн хуульч эсвэл Оюуны Өмчийн Газартай холбоо тогтоосноор зардлаа хэмнэх боломжийн хамгаалалтыг хайж олоход тавигдах шаардлагууд болон бусад боломжуудыг нарийвчлан мэдэж авч чадна.

Олон Улсын Ангиллын Тогтолцоо

Бүтээгдэхүүний загварын хайлт хийхэд хялбар болгох үүднээс ерөнхийд нь анги ангид хуваан ангилсан байдаг. Мэдүүлгийн маягтад буй асуулгад та загвараа ямар зориулалтаар хэрэглэхийг төлөвлөж байгаагаа хэлэхийн тулд бүтээгдэхүүний хамаарах ангиллыг мэдэж байх шаардлагатай юм.

Хайлт шүүлт хийх болон хэвлэлд ашиглах зорилгоо Олон Улсын Ангиллын Локарногийн ангиллыг манай орон хэрэглэдэг.

Монгол Улс Бүтээгдэхүүний Загварын Олон Улсын Ангиллын Локарногийн Хэлэлцээрт 2000 онд нэгдэн орсон билээ.

Бүтээгдэхүүний Загварын Олон Улсын Ангиллын Локарногийн Хэлэлцээрийн ангиллыг манай орон хэрэглэдэг.(хавсралт II-т буй Ангиллын жагсаалтыг харна уу).

Мөн: www.wipo.int/classification/en/locarno/about/ -с харна уу

Та бүтээгдэхүүний загвараа лицензийн гэрээгээр ашиглуулж болох уу?

Бүтээгдэхүүний загварын зохион бүтээгч (лицензи олгогч) өөр этгээдэд (лицензи авагч) харилцан тохиролцсны үндсэн дээр бүтээгдэхүүний загвараа ашиглуулах зөвшөөрлийг олгосноор бүтээгдэхүүний загвар лицензлэгдэнэ. Энэ тохиолдолд, хоёр тал хугацаа, гэрээний зорилго, цар хүрээг тодорхойлсны үндсэн дээр **лицензийн гэрээ** хийгдэнэ.

Лицензийн гэрээ нь лицензи авагч бүтээгдэхүүний загварыг ашиглах, лицензи олгогдох хугацаа болон лицензи ашиглах бүтээгдэхүүний хэлбэр зэрэг хязгаарлалтуудыг агуулсан байдаг. Гадаад орнуудад лицензийн гэрээгээр бүтээгдэхүүний загварыг хэрэглүүлэхийн тулд та өмнө нь тухайн орондоо бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт хийлгэсэн эсвэл мэдүүлэг гаргасан байх хэрэгтэй байдаг.

Бусдад лицензийн гэрээгээр бүтээгдэхүүний загвараа та хэрэглүүлэхийг зөвшөөрснөөр таны бизнест ашиг орлогын нэмэлт эх үүсвэрүүд бий болох боломжтой болно. Мөн энэ нь бүртгэгдсэн бүтээгдэхүүний загвараар компаний онцгой эрхийг ашиглах энгийн агуулгатай юм.

Бүтээгдэхүүний загварыг лицензээр ашиглуулах гэрээ хэлэлцээр нь ихэвчлэн бүтээгдэхүүний (жишээ нь зөвхөн гаднах харагдах байдал биш) бүхий л талыг багтаасан өргөн цар хүрээтэй байдаг.

3. Дизайнаа гадаадад хамгаалах нь

Бүтээгдэхүүний загварыг гадаадад яагаад хамгаалдаг вэ?

Хэрэв танай компани жинхэнэ эх загварын бүтээгдэхүүнээ гадаадад хамгаалуулахаар төлөвлөж байгаа бол, эсвэл үйлдвэрлүүлэхээр лицензлэх хүсэлтэй байгаа бол, гадаад орнууд дах бусад фирмүүдэд энэхүү бүтээгдэхүүнийг худалдаалах эсвэл экспортлох бол, тэдгээр орнуудад энэхүү бүтээгдэхүүний загварыг хамгаалуулснаар дотоодын зах зээл дээр ашиглагддаг шигээ гадаадад хийгдсэн бүтээгдэхүүний загварын хамгаалалтаараа нэгэн адил ашиг орлого олох боломжоор хангагдана.

Та бүтээгдэхүүний загвараа гадаадад хэрхэн хамгаалах вэ?

Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт нь нутаг дэвсгэрийн шинжтэй юм. Энэ нь юу гэсэн утгатай вэ гэвэл бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт нь таны бүтээгдэхүүний загвараа бүртгүүлсэн тухайн орноор хязгаарлагддаг. Эндээс, хэрэв та экспортын зах зээл дээр хамгаалагдсан бүтээгдэхүүний загвараа гаргахыг хүсэж байгаа бол та тэдгээр сонгосон орнууддаа хамгаалалт хийлгэж болох эсэх талаар баттай мэдэж авах болно.

Энэ нь бүтээгдэхүүний загвараа хамгаалуулахаар эхний оронд мэдүүлэг гаргасан огнооноос хойш дараагийн бусад орнуудад мэдүүлэг гаргах хүртэл та ихэвчлэн 6 сар зарцуулахыг мэдэж байх нь маш чухал ач холбогдолтой. Энэ хугацаа өнгөрөхөд таны бүтээгдэхүүний загвар шинэлэг байх чадвараа удаан хадгалж чадахгүйгээс гадаадад орнуудад бүтээгдэхүүний загвараа хамгаалуулахаар мэдүүлэх боломжгүй болно.

Та бүтээгдэхүүний загвараа гадаадад хамгаалуулах үндсэн хоёр арга зам бий.

1. Үндэсний шугамаар: компаниуд эрхийн хамгаалалт хийлгэхийг хүссэн орон бүртээ тухайн орны үндэсний аж үйлдвэрийн өмчийн байгууллагад тусдаа мэдүүлэг гарган эрхийн хамгаалалт олж авч болно. Хамгаалалтын үйл ажиллагаа нь үндсэндээ их хүнд хэцүү байдаг эсвэл, тухайн үндэсний хэл рүү орчуулах үнэ өндөр түүнчлэн зохион байгуулалтын хураамжийн төлбөр шаарддаг.

2. Олон улсын шугамаар: Монгол Улс 1997 онд Бүтээгдэхүүний Загварын Олон Улсын Ангиллын Хадгалалтын тухай Гаагийн Хэлэлцээрт нэгдэн орсон. Нэлээд хэдэн оронд өөрийн бүтээгдэхүүний загвараа бүртгүүлэхийг хүссэн компаниуд ДООБайгууллагын гаргасан хэлэлцээр болох **Бүтээгдэхүүний Загварын Олон Улсын Хадгалалтын Тухай Гаагийн Хэлэлцээрээр** олгогдсон үйл ажилагааг ашиглаж олон улсын хамгаалалт хийлгэж болно. Монголын мэдүүлэг гаргагч нь ДООБайгууллагад олон улсын хадгалалт хийлгэх нэг мэдүүлэг гаргадаг. Тухайн бүтээгдэхүүний загвар нь мэдүүлэг гаргагчийн хүсэж сонгосон хэлэлцээрийн гишүүн олон оронд (одоогоор 38 орон гишүүн) хамгаалагдана. Энэхүү хэлэлцээр, мэдүүлэг гаргагч олон оронд бүтээгдэхүүний загвараа бүртгүүлэх хялбар мөн хямд арга замыг хангадаг юм. Хавсралт III-с Гаагийн Хэлэлцээрийн гишүүн орнуудын нэрийн жагсаалтыг харна уу. Гаагийн хэлэлцээрийн тухай, Мэдүүлгийн маягтыг хамруулсан бүрэн мэдээллийг ДООБайгууллагын вэбсайтын <http://www.wipo.int/hague/> хаягаар олж авч чадна.

Гаагийн хэлэлцээрийн дагуу хийгдэх бүтээгдэхүүний загварын хамгаалалтын **үнэ** нь хамгаалалтаа хичнээн оронд хийлгэхийг хүсч байгаа болоод хэдэн бүтээгдэхүүний загвар бүртгүүлэх гэж байгаагаас хамаарч өөр өөр байна. Жишээ нь, Гаагийн системийн санал болгож буй олон улсын шугамыг ашиглан 11 оронд 5 бүтээгдэхүүний загвар хамгаалуулахад 900 орчим Швейцарь Франк байдаг байна.

Бүтээгдэхүүний загварын олон улсын эрхийн хамгаалалт

2001 онд, бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын Гаагийн Системийг ашигладаг 10 томоохон хэрэглэгчийг тэдний мэдүүлсэн мэдүүлгийн тоогоор байр эзлүүлэхэд Swatch Group, Interior, Sony Overseas, Hermes, Daimler Chrysler, Nokia, Villeroy, Moulinex, Philips Electronics болон Salomon компаниуд байсан. Тэр жилдээ, Swatch Group нь Гаагийн Системийг ашиглан бүтээгдэхүүний загвараа бүртгүүлэх 103 мэдүүлэг хадгалуулж энэхүү системийн хамгийн том хэрэглэгч болсон байна. Swatch-ийн цагнуудын ялгарах шинж бүхий “гадаад төрх” нь өөрийн бүтээгдэхүүнээр дамжуулан хэрэглэгчийн сонголтод нөлөөлөх маш чухал онцлог шинж болжээ. Эндээс харахад, Swatch Group шиг компаниуд тэргүүлэх бүтээгдэхүүний загварыг сайжруулан хөгжүүлэхэд ихээхэн хэмжээний мөнгөн хөрөнгө оруулалт болон судалгаа шинжилгээний ажил зарцуулаад, мөн олон оронд тэдгээр бүтээгдэхүүний загвараа бүртгүүлснээр тэд загвар дизайнаа хөгжүүлэх онцгой эрхийг олж авна гэдэгт итгэлтэй байдаг байна.



Зөвшөөрсөн: *Swatch A.G: Бугуйн цаг*

4. Бүтээгдэхүүний загвараа алдахаас сэргийлэх нь

Таны бүтээгдэхүүний загварыг дууриалгаж, хуулбарлаж мөн зөвшөөрөлгүй хэрэглэж байгаа үед та өөрийн эрхээ алдахаас хэрхэн сэргийлэх вэ?

Аль нэг аж үйлдвэрийн өмчийн эрхийг алдахаас сэргийлэх нь хэцүү ярвигтай асуудал юм. Энэ нь эрх мэдэл бүхий оюуны өмчийн хуульчийг олж мэргэжлийн түвшинд хамтран ажиллах явдал хамгийн зөвлүүштэй зүйл билээ. Бүтээгдэхүүний загварыг эзэмшигчээс нь хулгайлсан зөрчил мөн хуулбарласан, дууриалгасныг тогтоох үүрэг болон үйл ажиллагаа маш ач холбогдолтой гэдгийг санаж байх хэрэгтэй. Өөр өөр хэлбэл, **та өөрөө зах зээл дээр өөрийн бүтээгдэхүүний загварын хэрэглээг шалган хянах, аль нэг хуулбарлагч болон дууриалгагч этгээдийг илрүүлэх түүнчлэн тэдний эсрэг хэрхэн хэзээ хэрэг үүсгэхийг шийдвэрлэх үүрэгтэй.**

Оюуны өмчийн хуульч нь таны бүтээгдэхүүнийг хуулбарлагч, хууль бусаар ашиглагч болон хуулбарлагчийг мөрдөн шүүх ба маргааныг хэрхэн таслах талаар зөвлөлгөө өгөх зэрэг танай оронд тогтсон боломжуудын тухай танд мэдээлэл өгөх ердийн эрх бүхий хүн байдаг.

Хэдийд ч **зөрчил** гардгийг та мэдэж байх хэрэгтэй. жишээ нь хэн нэгэн анхаарал санамсаргүйгээр худалдаалсан эсвэл загварыг бүтээгдэхүүндээ авч ашигласан нь таны онцгой эрхийг зөрчиж байгаа бол, тэр эрэгтэй/тэр эмэгтэй-д түүний бүтээгдэхүүний загвар болон таны онцгой эрхийн хооронд үүсэж болох зөрчилдөөнийг мэдээлж “шударга бус ажиллагааг зогсоох мэдэгдэл”-г илгээх анхны алхмыг та хийж болно. Тэр захианы төсөл нь хуульчаар баталгаажуулагдсан байна. Хэрэв зөрчил янзандаа үргэлжилсээр байвал шаардлагатай гэж үзвэл зөрчил гаргагчийн эсрэг хуулийн дагуу хэрэг үүсгэж болно.

Зөрчил мөн гэдэгт та итгэлтэй байгаа бол түүнчлэн зөрчилтэй үйлдэл явагдаж байгаа байрлалыг мэдэж буй тохиолдолд эрэн сурвалжлах ба баривчлах зөвшөөрлийг үндэслэн (ихэвчлэн эрх бүхий шүүх эсвэл цагдаагийн газраас авдаг) хууль бус үйлдэл хийгч компанид/хувь хүнд өмнө мэдэгдэл өгөхгүйгээр дайралт зохион байгуулах гэнэтийн үйл ажиллагааг авч явуулах боломжтой болно.

Зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг гадаадаас оруулж ирэхээс урьдчилан сэргийлэхийн тулд, олон улсын хил хязгаар дээрх арга хэмжээнүүдэд бүтээгдэхүүний загварын эзэмшигч өөрийн орны гаалийн зөвшөөрлөөр олон оронд гаргах боломж юм.

Ерөнхий дүрмээр, хэрэв зөрчил мөн хэмээн тогтоогдсон бол, мэргэжлийн хуулийн зөвлөлгөөг хайх нь хамгийн зөвлүүштэй зүйл билээ.

5.Бүтээгдэхүүний загварыг хамгаалах бусад эрх зүйн баримт бичгүүд

Бүтээгдэхүүний загварын хувьд зохиогчийн эрхийн хамгаалалт ба бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтын хоорондын ялгаа юу вэ?

Монголд, зохиогчийн эрхийн хууль тогтоомжоор тодорхой загваруудын хувьд зохиогчийн эрхийн хамгаалалт хийхийг хүлээн зөвшөөрдөг, жишээлбэл, хивсний загварт.



Зөвшөөрсөн: “Улаанбаатар Хивс” ХХК: Хивс

Та нэгтгэсэн хамгаалалтыг хийлгэж болох боловч, энэ зохиогчийн эрхийн хамгаалалт ба бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт нь ижил бүтээгдэхүүний загварын хувьд нэгэн зэрэг давхцан оршиж болно.

Таны бүтээгдэхүүний загварт аль хамгаалалт нь илүү сайн болох аливаа шийдвэр гаргахаас өмнөх анхны алхам нь энэ хоёр хамгаалалтын хэлбэрийн хоорондын ялгааг ойлгож мэдэх явдал юм. Зарим үндсэн ялгаануудыг доор товчилбол:

Бүртгэл

- Патентийн тухай хуулийн дагуу бүтээгдэхүүний загварт үндсэндээ хэвлэгдэхээс өмнө эсвэл олон нийтийн хэрэглээнд гарахаас өмнө дор хаяж хамгаалалт хүссэн тухайн орондоо мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр **бүртгэгдсэн** байхыг шаарддаг. Патентийн тухай хуулиар олгогдсон **бүтээгдэхүүний загварын патент** нь зөрчил маргааны үед ашигтай нь батлагдана. Та өөрийн онцгой эрхээ алдахаас урьдчилан сэргийлэхэд мэдэгдэхүйц бодит үндэс болж өгнө.
- Урлаг уран сайхны шинж агуулсан гэж үзэж буй бүтээлийн зохиогчийн эрх нь дагаж мөрдөх дүрэм журамгүйгээр оршин тогтноно. **Эрхийн хамгаалалтад бүртгэл чухал биш байдаг ч**, та Монголд бүтээгдэхүүний загвараа хадгалуулж патент авсан байлаа ч, зохиогчийн эрхийн хадгалалтын сан нь нэгэн зэрэг оршдог.

Хугацаа

- Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт нь үндсэндээ **10 жилийн** хугацааны туршид үргэлжилдэг. Бүтээгдэхүүний загварын бүртгүүлэх үйл ажиллагаа нь тодорхой цаг хугацаа зарцуулдаг, мөн бүтээгдэхүүний хувьд үргэлжлэх өгөгдсөн хугацаа нь байнга шаардлага хангадаггүй гэдгийг оюун санаандаа тогтоож авах хэрэгтэй юм. (жишээ нь: хувцас загварын бүтээгдэхүүнүүдэд)
- Зохиогчийн эрх нь ихэнх орнуудад зохиогчийн **насан туршид мөн нас барснаас хойш 50 эсвэл 70 жил** үргэлжилнэ.

Хамгаалалтын цар хүрээ

- Бүтээгдэхүүний загварын бүртгэлээр олгогдсон эрх нь зөрчил байна эсвэл санаатайгаар урьдаас тооцоолон хуулбарлан олшруулаагүй байна хэмээн тогтоох боломжтой **үнэмлэхүй эрх** байдаг.

- Зохиогчийн эрхийн хуулийн дагуу, зохиогчийн эрх хүчинтэй үед л тухайн **бүтээлийг санаатайгаар хувилсан тохиодолд зөрчил** хэмээн үзнэ. Зөрчил гэж үзсэн тохиодолд энэ нь түүнээс сэргийлэхийн тулд маш хүнд хэцүү болоод үнэтэй болгодог байна.

Бүтээгдэхүүний хэлбэрүүд

Манай оронд, **зохиогчийн эрхээр бүх бүтээгдэхүүний загварыг хамгаалдаггүй**, гэвч эхний ээлжинд урлагийн бүтээл гэж ойлгогдохуйц тэдгээр бүтээгдэхүүнүүд багтаж болно. Ялгаа нь ил тодорхой ялгарах шинжгүй зарим загварууд зохиогчийн эрхийн хуулиар хамгаалагдах боломжгүй байдаг, үүнд үйлдвэрлэлийн аргаар хийгдсэн бүтээгдэхүүнүүдийн хэлбэр багтана. Харин бусад зүйлс, үүнд нэхмэлийн даавуун эдлэлийн загварууд, эдгээр хоёр хамгаалалтын хэлбэрт хамаарах боломжтой байдаг байна.

Үнэ

Та өөрийн бүтээгдэхүүний загвараа бүртгүүлэхдээ тохирсон хураамжийг төлөх хэрэгтэй болно гэдэг утгаар хураамжийг сонирхож үзэх хэрэгтэй. Нэмж хэлэхэд, энэ нь ашиг тустай мөн аж үйлдвэрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр өөрийгөө төлөөлүүлж, мэдүүлэг өгүүлэх үйлчилгээ хийлгэхэд мөн түүнчлэн нэмэлт үнэ зардал гаргах зэрэгт чухал шаардлагатай байх болно.

Зохиогчийн эрхээр хамгаалагдаж олгогдсон бүтээлийн албан ёсны бус бүртгэл нь ихэнх үндэстнүүдийн зохиогчийн эрхийн хуулиар хамгаалагдсан байхыг шаарддаг. Үндсэндээ зохиогчийн эрхийн хамгаалалтад хамаарах тогтмол үнэ байдаггүй. Гэвч, тухайн бүтээл гарсан орондуудад : (а) бүтээлийн хамгаалалтаас, (б) маргаан гарсан тохиолдолд эзэмшигчийн баталгааг гаргах зэргээс үнэ хамаарна.

Дүгнэвэл, бүртгэгдсэн бүтээгдэхүүний загвараар олгогдсон эрхийн хамгаалалт нь хүчтэй хамгаалалт байдаг. Энэ нь санаатай бус зөрчилд өртөх болон бүтээгдэхүүний загварын патент нь зөрчил үүсэх тохиолдолд ач холбогдол бүхий баталгаа болж өгдөг байна, энэ нь ихээхэн үр дүнтэй хамгаалалт (санхүүгийн болон зохион байгуулалтын) болдог, яагаад гэвэл бүртгэлийг шаарддаг, мөн түүнчлэн тодорхой хугацааны хязгаарлалттай байна.

Ямар ч тохиолдолд, ялангуяа бүтээгдэхүүний загвар бүртгэгдээгүй бол, тухайн загварыг сайжруулан хөгжүүлэх бүхий л үе шатандаа барааныхаа тухай тайланг нууцлах нь зүйтэй хэмээн зөвлөмөөр байна. Ноорог эскиз бүрээ огноожуулж, баталгаажуулан архивлаж хадгалах явдал нь зөрчил илэрсэн тохиодолд тус болж чадна.

Жишээ нь: Английн даавууны дизайнеруудын өнөөгийн судалгаагаар, судалгаанд оролцогсдын 80% нь тэд өөрсдийн жинхэнэ загварын баримт бичгийг байнга нууцлан хадгалдаг мөн зохиогчийн эрхийн эзэмшигчийг баталгаажуулахын ач холбогдлыг ойлгож ухамсарласан хэмээжээ.

Бүтээгдэхүүний загварыг барааны тэмдгийн хуулиар хэдийд хамгаалж болох вэ?

Барааны тэмдэг гэдэг бол (ерөнхийдөө үгэн тэмдэг, дүрсэн эсвэл тэр хоёрын хослол байна) тухайн компаний бүтээгдэхүүнийг бусад компаний ижил төрлийн бүтээгдэхүүнээс ялгахад хэрэглэдэг ялгарах шинжтэй тэмдэг юм. Тухайн бүтээгдэхүүний хэлбэр, загвар болон сав баглаа боодлын нөхцөл байдалд тохируулан бүтээгдэхүүнийг өвөрмөц ялгарах шинжтэй гэж үзвэл гурван хэмжээст барааны тэмдгээр баталгаажуулж болно.



Зөвшөөрсөн: “Нэн Шинэ” ХХК: Сав баглаа боодол

Энэ нь аж үйлдвэрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт тодорхой бүтээгдэхүүний загвар гурван хэмжээст барааны тэмдэг маягаар байж болохыг мэдэж авах ашигтай зөвлөлгөө болно.

Барааны тэмдгийн эрхийн хамгаалат нь хязгааргүй дахин шинэчлэгдэх боломж бүхий давуу талтай байдаг, харин бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт нь ихэвчлэн хязгаарлагдмал хугацааны дотор л (үндсэндээ 10жил) хамгаалагдах боломжтой юм. Мөн барааны тэмдгийн бүртгэлийн үнийг бүтээгдэхүүний загварын бүртгэлийн үнэтэй харьцуулахад ялгаатай байдаг. Монголд, эдгээр хоёр төрлийн хамгаалалт нь зэрэгцэн оршиж байдаг.

Шударга бус өрсөлдөөний хуулиар таны бүтээгдэхүүний загвар хамгаалагдах уу?

Манай оронд бүтээгдэхүүний загварыг мөн шударга бус өрсөлдөөний хуулиар хамгаалдаг. Бүтээгдэхүүний загвар нь шударга бус өрсөлдөөнийг хориглох хуулийн дагуу, төөрөгдөлд оруулахын эсрэг, хуулбарлахын эсрэг , гуравдагч эдгээдийн нэр хүндэд халдахын эсрэг зэрэг заалтуудаар хамгаалагдаж болно. Гэвч, шударга бус өрсөлдөөний хуулийн дагуух эрхийн хамгаалалт нь үндсэндээ мэдэгдэхүйц доогуур түвшинд байдаг ба зөрчлийг олж тогтооход маш хүнд байдаг байна.

Цаашид мэдээлэл олж авахад хэрэглэгдэх вебсайтууд:

Монгол Улсын Оюуны Өмчийн Газар:

www.ipom.mn

Бизнесийн хэтийн төлөвлөлтийн талаарх оюуны өмчийн бусад хэвлэлүүд:

www.wipo.int/sme/

Бүтээгдэхүүний загварын талаар ерөнхийд нь:

www.wipo.int/about-ip/en/

Бүтээгдэхүүний загварын бүртгэлтэй холбогдсон практикийн асуудлуудын талаар Хавсралт I –т буй үндэсний болоод бүсийн оюуны өмчийн газруудын вебсайтын хаягын жагсаалтаас харна уу, эсвэл :

www.wipo.int/news/en/links/ipo_web.htm.

Бүтээгдэхүүний загварын Олон Усын Хадгалалтын Талаарх Гаагийн Хэлэлцээрийн талаар:

www.wipo.int/hague/en/

Бүтээгдэхүүний загварын Олон Улсын ангилал тогтоох Локарногийн Хэлэлцээрийн талаар:

www.wipo.int/classifications

(Локарногийн Хэлэлцээрийн дагуу)

Арбитрийн болоод зуучлалын талаар:

<http://arbiterwipo.int/>

ХАВСРАЛТ I

**Үндэсний болон Бүсийн Аж Үйлдвэрийн Өмчийн Байгууллагуудын
Вэб сайтын Хаягууд**

| | |
|---|---|
| ARIPO (Африкийн Бүсийн Аж Үйлдвэрийн Өмчийн Байгууллага) | http://www.aripo.wipo.net |
| Алжир | http://www.inapi.org |
| Андора | http://www.ompaa.ad |
| Аргентин | http://www.inpi.gov.ar |
| Армени | http://www.armpatent.org |
| Австри | http://www.patent.bmwa.gv.at |
| Австрали | http://www.ipaustralia.gov.au |
| Барбадос | http://www.caipo.org.bb/ |
| Бельги | http://www.european-patent-office.org/patlib/country/belgium |
| Белиз | http://www.belipo.bz |
| Бенелюх (Бенелюксийн Дизайны Газар-BDO) | http://www.bbtm-bbdm.org |
| Боливи | http://www.senapi.gov.bo |
| Босния Герцоговина | http://www.bih.net.ba/zsmp |
| Бразил | http://www.inpi.gov.br |
| Болгар | http://www.bpo.bg |
| Канад | http://www.cipo.gc.ca |
| Хятад | http://www.sipo.gov.cn |
| Хятад (Гонг-конг- SAR) | http://www.info.gov.hk/ipd |
| Хятад (Макао) | http://www.economia.gov.mo |
| Чили | http://www.proind.gov.cl |
| Колумби | http://www.sic.gov.co |
| Конго | http://www.anpi.cg.wipo.net |
| Коста Рика | http://www.registronacional.go.cr |
| Хрват | http://www.dziv.hr |
| Куба | http://www.ocpi.cu |
| Чех | http://www.upv.cz |
| Дани | http://www.dkpto.dk |
| Доминикан Улс | http://www.seic.gov.do/onapi |
| Египит | http://www.egypo.gov.eg |
| Эстония | http://www.epa.ee |
| Европийн холбоо (Дотоодын зах зээлд зохицуулах байгууллага ОНИМ) | http://www.oami.eu.int/ |
| Финланд | http://www.prh.fi |
| Франц | http://www.infi.fr |
| Гүрж | http://www.sakpatenti.org.ge/ |
| Герман | http://www.dpma.de |
| Грек | http://www.gge.gr |
| Унгар | http://www.hpo.hu |
| Исланд | http://www.els.stjr.is |
| Энэтхэг | http://www.patentoffice.nic.in |
| Индонез | http://www.dgip.go.id |

| | |
|---|---|
| Ирланд | http://www.patentsoffice.ie |
| Израил | http://www.justice.gov.il/rasham+haptentim |
| Итали | http://www.european-patent-office.org/it |
| Япон | http://www.jpo.go.jp |
| Ёрдан | http://www.mit.gov.jo |
| Казакстан | http://www.kazpatent.kz |
| Кеня | http://www.kipo.ke.wipo.net |
| Киргизстан | http://www.krygyzpatent.kg |
| Бүгд Найрамдах Лаос Улс | http://www.stea.la.wipo.net |
| Литиниа | http://www.vpb.lt |
| Люксенбург | http://www.etat.lu/ec |
| Макао | http://www.economia.gov.mo |
| Малайз | http://www.kpdnhq.gov.my |
| Мексико | http://www.impi.gob.mx |
| Моноко | http://www.european-patent-office.org/patlib/country/monaco |
| Монгол | http://www.ipom.mn |
| Мороко | http://www.ompic.org.ma |
| Голланд | http://www.bie.minez.nl |
| Непал | http://www.ip.np.wipo.net |
| Шинэ Зеланд | http://www.iponz.govt.nz |
| Норвег | http://www.patentstyret.no |
| ОАПИ (Африкийн Оюуны Өмчийн Байгуулага) | http://www.oapi.wipo.net |
| Панам | http://www.mici.gob.pa/comintf.html |
| Перу | http://www.indecopi.gob.pe |
| Филиппин | http://www.ipophil.gov.ph |
| Польш | http://www.uprp.pl |
| Португал | http://www.inpi.pt |
| Солонгос | http://www.kipo.go.kr |
| Македоний Улс | http://www.ippo.gov.mk |
| Молдав Улс | http://www.agepi.md |
| Румин | http://www.osim.ro |
| Оросын | http://www.rupto.ru |
| Холбооны Улс | |
| Серби Монтенегро | http://www.yupat.sv.gov.yu |
| Сингапур | http://www.ipos.gov.sg |
| Словяк | http://www.indprop.gov.sk |
| Словяни | http://www.sipo.mtz.si |
| Испани | http://www.oepm.es |
| Швед | http://www.prv.se |
| Швецарь | http://www.ige.ch |
| Тажекстан | http://www.tipat.org |
| Тайланд | http://www.iptailand.org |
| Турк | http://www.turkpatent.gov.tr |
| Украин | http://www.ukrpatent.org |
| Англи | http://www.patent.gov.uk |
| Америкийн | http://www.uspto.gov |
| Нэгдсэн Улс | |
| Уругвай | http://www.dnpi.gub.uy |
| Узбекстан | http://www.patent.uz |

ХАВСРАЛТ II**Локарний хэлэлцээрийн дагуух
Бүтээгдэхүүний Загварын Олон Улсын Ангилал****АНГИЛЛЫН ЖАГСААЛТ**

1. Хүнсний бүтээгдэхүүн
2. Хувцас болон жижиг барааны хэрэгсэл
3. Аялал жуучлалын зориулалттай бүтээгдэхүүн, хайрцаг, жижиг шүхэр болон хувийн хэрэглээний эд зүйлс, тусгайлан ангилаагүй ижил зүйлс
4. Сойзон эдлэл
5. Ширхэгийн нэхмэл бүтээгдэхүүн, байгалийн гаралтай болон хиймэл бүрэх материал
6. Тавилга
7. Гэр ахуйн эдлэл хэрэглэл, тусгайлан ангилаагүй ижил зүйлс
8. Хөдөлмөрийн багаж хэрэгсэл болон техник хангамж
9. Бүтээгдэхүүнийг зөөж тээвэрлэх болон худалдаалахад зориулсан сав баглаа боодол
10. Цаг, бугуйн цаг болон бусад хэмжих багаж хэрэгсэл, тоолуурын болон дохиоллын багаж хэрэгсэл
11. Гоёл чимэглэлийн зүйлс
12. Тээврийн болон зөөврийн хэрэгсэл
13. Цахилгааныг үйлдвэрлэх, хуваарилах, мөн хувиргах зориулалттай тоног төхөөрөмж
14. Пянзны бичлэг, харилцаа холбоо болон мэдээлэл буцаах тоног төхөөрөмж
15. Машин, тусгайлан ангилаагүй ижил зүйлс
16. Фото зураг, кинозураг болон дуран авиан аппарат
17. Хөгжмийн зэмсэг
18. Хэвлэгч болон албан тасалгааны тоног төхөөрөмж
19. Бичиг хэргийн болон албан тасалгааны зориулалттай тоног төхөөрөмж, жүжигчний болон сургалтын хэрэгсэл
20. Худалдаа наймааны болон зарлал сурталчилгааны тоног төхөөрөмж, томъёолсон тэмдэг
21. Тоглоом наадгай, майхан асар болон спортын бараа бүтээгдэхүүн
22. Буу зэвсэг, галт зэвсгийн хэрэгсэл, ан агнах, загасчлах болоод хортон шавьж устгах хэрэгсэл
23. Шингэн хуваарилах тоног төхөөрөмж, эрүүл ахуйн, халаалтын, агааржуулалтын болоод агаар үлээх тоног төхөөрөмж, хатуу түлш
24. Эмнэлгийн болон лабораторийн тоног төхөөрөмж
25. Барилгын бүрдэл хэсэг болон байгууламжийн элемент
26. Гэрэлтүүлгийн аппарат
27. Тамхи болон тамхичины хэрэглээний эд зүйлс
28. Эмийн болон гоо сайхны бүтээгдэхүүн, бие засах газрын хэрэгсэл болон аппарат
29. Осол болон хохирлоос сэргийлэх зорилготой гал эсэргүүцэх төхөөрөмж болон тоноглол
30. Амьтныг тэжээх асрахад зориулсан хэрэгсэл
31. Хоол хүнс болон ундаа бэлтгэх зориулалттай машин болон хэрэгсэл, тусгайлан ангилаагүй ижил зүйлс
32. Бусад зүйлс

ХАВСРАЛТ III

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ОЛОН УЛСЫН ХАДГАЛАЛТЫН ТАЛААРХИ ГААГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ГИШҮҮН ОРНУУД (2004 оны 4 сарын байдлаар)

Бельги
Белиз
Бенин
Болгар
Кот Ивори
Хрват
Ардчилсан Солонгос Ард Улс
Египэт
Эстония
Франц
Габон
Гүрж
Герман
Грек
Холли Сий
Унгар
Исланд
Индонейз
Итали
Киргизстан
Лихтейнштэн
Люксембург
Монако
Монгол
Морокко
Намибия
Голланд
Молдав Улс
Румин
Сенегал
Серби болон Монтенегро
Слования
Испани
Суринам
Швейцарь
Македоний Югославийн Вант Улс
Туниси
Украин

Гишүүн орнууд: 38

ХАВСРАЛТ IV

Санамж : Өргөдлийг бичгийн машинаар болон

ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАРТ

Улаанбаатар 46
Бага тойруу 49

**Бүтээгдэхүүний загварын
өргөдөл**

Өргөдөлд хавсаргасан
мэдүүлгийг хянаж патент
олгохыг хүсье.

Мэдүүлгийн улсын
бүртгэлийн дугаар ...

Анхдагч огноо

... он ... сар ... өдөр

Давамгайлах огноо

... он ... сар ... өдөр

Олон улсын ангилал ...

1.Бүтээгдэхүүний загварын нэр

Бүтээгдэхүүний загварын мэдүүлгийг үндэслэн

..... нэр дээр патент олгоно уу

71/ мэдүүлэг гаргагчийн овог нэр,

Шуудангийн хаяг, утас,
телекс

72/ Зохиогчийн овог, нэр

Шуудангийн хаяг, утас,
телекс

Өөрийн улсын нэр

Оршин суугаа орны нэр.....

72/ Зохиогчийн овог, нэр

Шуудангийн хаяг, утас,
телекс

Өөрийн улсын нэр.....

Оршин суугаа орны нэр.....

2.Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, шуудангийн хаяг
Утас Телекс

Телефакс

3.Загварын тодорхойлолт /мөн чанар, өвөрмөц байдал, хэлбэр хийцийг 250-300 үгэнд багтаан тодорхойлж бичнэ/.

4.Мэдүүлэгт хавсаргасан зүйлс

- итгэмжлэх болон төлөөлөгчийн эрхийн тухай хуулбар хуудас
- зурсан зураг ширхэг
- хар цагаан гэрэл зураг ширхэг
- өнгөт гэрэл зураг ширхэг
- хуулбарласан зураг ширхэг

5.Мэдүүлэг гаргагч буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, гарын үсэг